

UCS 2001A:2023

ДУУ ЧИМЭЭНИЙ БОХИРДОЛ




Дуу чимээний бохирдлын менежмент

ДУУ ЧИМЭЭНИЙ БОХИРДОЛ

Дуу чимээний бохирдлын менежмент

*Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 37-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	4
2. Норматив эшлэл.....	4
3. Нэр томъёоны тодорхойлолт.....	4
4. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага	5
5. Дуу чимээний хүлцэх хэмжээ	8
6. Дуу чимээг хэмжих, хянах хэрэгсэл	10
7. Ногоон байгууламжийн төлөвлөлт	12
8. Төмөр замын төлөвлөлт	13
9. Барилга, орон сууцны дуу чимээний шалгуур үзүүлэлт	14
Ашигласан материалын жагсаалт	16

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Орон сууцны хороололд нүүрэн талын барилга байгууламж төлөвлөх загвар.....	6
Зураг 2. Дуу чимээнээс хамгаалагдсан орон сууцыг гол замд ойр байхаар төлөвлөх.....	6
Зураг 2.1 Дуу чимээнээс хамгаалагдсан орон сууцны дотоод зохион байгуулалт	7
Зураг 3. Орон сууцны барилгад тагт төлөвлөх	7
Зураг 4. Орчны дуу чимээний хүлцэх хэмжээ	8
Зураг 5. Дуу чимээ хэмжигч багаж	10
Зураг 6. Дуу чимээг тогтмол хянах төхөөрөмж	11
Зураг 7. Гэрэлтүүлгийн шонд суурилуулсан мэдрэгчийн байрлал	11
Зураг 8. Модны дуу чимээ бууруулах үйлчлэлийн хэмжээ	12
Зураг 9. Ногоон зурвасын төлөвлөлтийн жишээ.....	12
Зураг 10. Зам дагуу ногоон байгууламж төлөвлөх	13
Зураг 11. Төмөр замын төлөвлөлт	14

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ.....	5
Хүснэгт 2. Тээврийн хэрэгслийн гаднах дуу чимээний хүлцэх түвшин	9
Хүснэгт 3. Тээврийн хэрэгслийн доторх дуу чимээний хүлцэх түвшин	9
Хүснэгт 4. Шалгах хуудас	15



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Г Дуу чимээний бохирдолд хамаарах Г
хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг; Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.1} дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн “Дуу чимээний бохирдол” бүлэгт хамаарах дор дурдсан хотын стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS2001A:2023 “Дуу чимээний бохирдлын менежмент” хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS2002A:2023 “Дуу чимээний бохирдлыг бууруулах технологи, арга зүйн удирдамж” хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;


1.3. UCS2001C:2023 “Дуу чимээ, дулаан тусгаарлах материалд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг гуравдугаар хавсралтаар.

2. Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо (Б.Мягмар)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100562

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 37 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



ДУУ ЧИМЭЭНИЙ БОХИРДОЛ

UCS 2001A:2023 “ДУУ ЧИМЭЭНИЙ БОХИРДЛЫН МЕНЕЖМЕНТ” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү хотын стандартыг дуу чимээний эх үүсвэр, дуу чимээг хүлээн авагч барилга байгууламж, дуу чимээний бохирдолд нөлөөлөгч хүчин зүйлсийг тооцоолох, төлөвлөхөд дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- БНБД 31-01-10, Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт;
- БНБД 30.01.04, Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын. Норм ба дүрэм;
- БНБД 23-05-10, Дуу чимээ тусгаарлалт;
- БНБД 31-08-05, Дуу, дулаан тусгаарлалтын ажил;
- MNS 0012.1.009:1985, “Хөдөлмөр хамгаалал. Шуугиан Орон сууц, иргэний барилгын шуугианы байж болох түвшин”;
- MNS 6768 :2019 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага”.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Дуу чимээний бохирдол – гэж хүний эрүүл мэнд, ан амьтан, хүрээлэн буй орчны чанарт сөрөг нөлөө үзүүлэх хүсээгүй эсхүл хүлцэх хэмжээнээс хэтэрсэн дуу чимээ.;

Дуу чимээний эх үүсвэр – гэж дуу чимээний бохирдол үүсгэж буй тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, тоног төхөөрөмж, үйл ажиллагаа;

Дуу чимээ хүлээн авагч - гэж дуу чимээний бохирдолд өртөж буй барилга байгууламж, хүн, амьтан;

Дуу чимээний хүлцэх хэмжээ – гэж дуу чимээний даралтын түвшний зөвшөөрөгдөх дээд хэмжээ;

Замын хөдөлгөөний дуу чимээ – гэж авто зам болон төмөр замын хөдөлгөөнөөс хүрээлэн буй орчинд тархах дуу чимээ;

Үйлдвэрийн дуу чимээ – гэж үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдах бүх төрлийн машин механизмаас үүсэх дуу чимээ;

Барилга угсралт, нураах ажлаас үүсэх дуу чимээ – гэж кран, цемент холигч, гагнуур, экскаватор зэрэг барилгын тоног төхөөрөмж, үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ;

Дууны давтамж - гэж нэг секундэд хэлбэлзэх долгионы хэлбэлзлийн тоог, хэмжих нэгж Герц [Гц];

Дууны даралт - гэж дууны долгион орчны агаар дахь хийн молекулуудыг хэлбэлзүүлж, агаарын даралтад үзүүлж буй өөрчлөлтийг, хэмжих нэгж Паскал [Па];

Дууны даралтын түвшин - гэж багажаар хэмжигдсэн дууны даралтын хураангуйлсан утгыг, хэмжих нэгж Децибел [дБА];

Дуу чимээний карт – гэж тухайн газар дээрх 5 дБА интервалтай янз бүрийн дууны түвшний шугамыг оруулсан дуу чимээний эх үүсвэртэй нутаг дэвсгэрийн карт.

4. ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Дуу чимээний бохирдол нь хүн амьтны нүдэнд үзэгдэж харагдахгүй, хүний эрүүл мэнд, мэдрэлийн системд хамгийн их нөлөөлдөг тул урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого арга зүйгээр хангах нь чухал юм.

- 4.1. Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн үе шатанд дуу чимээний аюулгүйн түвшинд тавигдах төлөвлөлтийн шаардлагуудыг харгалзан үйлдвэрийн бүс буюу бие даасан үйлдвэр, эрчим хүчний объект, агаарын тээвэр, төмөр зам, гудамж, замын сүлжээний дуу чимээний картыг гаргана. Дуу чимээний картыг Хотын стандарт, Хяналтын газар гаргана.
- 4.2. Үйлдвэрийн бүс, эрчим хүчний объект, агаарын тээврээс үүсэх дуу чимээг бууруулахад тухайн салбарын стандарт, норм, дүрмийг мөрдөж бохирдлыг арилгах арга хэмжээг авна.
- 4.3. Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах үе шат бүрд дуу чимээнээс хамгаалах арга хэмжээг заавал тусгана.
- 4.4. Суурьшлын бүсийг төлөвлөх, барилгажуулахад БНБД 23-05-10 Дуу чимээ тусгаарлалт нормын дагуу дуу чимээний зөвшөөрөгдөх түвшнийг хангах боломжийг харгалзан үзнэ.
- 4.5. Үйлдвэрийн дуу шуугиан, доргио чичиргээ, гаргах нөхцөлийг харгалзан эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтооно. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг дараах ангилалд авч үзнэ. Үүнд:


Хүснэгт 1. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ

Ангилал	Орчны нөлөөлөл	Хамгаалалтын бүсийн хэмжээ, м
I	Алслагдсан орчин хүртэл хүчтэй дуу чимээний бохирдол үзүүлэх нөлөөтэй, дуу чимээ нь 120 дБА-аас их	1000
II	Ойр орчиндоо ихээхэн дуу чимээний бохирдол үзүүлэх нөлөөтэй, дуу чимээ нь 100-120 дБА	500


III	Зөвхөн ойр тойрондоо дуу чимээний бохирдол үзүүлэх нөлөөтэй, дуу чимээ нь 80-100 дБА	300
IV	Орчиндоо бага дуу чимээний бохирдол үзүүлэх нөлөөтэй, дуу чимээ нь 80 дБА хүртэл	200

Тайлбар: Дуу чимээний нөлөөлөл нь барилга байгууламжийн гадна орчинд 60-100дБА тохиолдолд эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээг 50% хүртэл бууруулж төлөвлөхийг зөвшөөрнө.


- 4.6. Орон сууцны хорооллын төлөвлөлтөд үйлдвэрийн болон эрчим хүчний газар, авто зам, төмөр зам, нисэх буудал, тээврийн газар (ангилан ялгах станц, автобусны парк) эрүүл ахуй-хамгаалалтын /дуу чимээний хүчин зүйлээр нь ангилсан/ бүсчлэлийг төлөвлөж дагаж мөрдөнө.
- 4.7. Дуу чимээний бохирдлын эх үүсвэр рүү харсан талд орон сууцны бус зориулалттай дэлгүүр, гарааш, ахуйн үйлчилгээ, конторын зориулалттай барилгыг ашиглавал оновчтой. (Зураг 1).
- 4.8. Дуу чимээний тархалтыг хязгаарлах ямар нэгэн хаалтгүй тохиолдолд дуу чимээний эх үүсвэрээс хамгийн багадаа 100 метрийн зайд төлөвлөнө.



Барилгыг дуу чимээний хаалт болгон ашиглах




Гол замын дагууд эгнээ орон сууцыг төлөвлөж орон сууцны хорооллын дуу чимээнээс хамгаалах



Орон сууцнуудын ойролцоо гараж, ногоон байгууламж байгуулж нам гүм орчныг бүрдүүлэх

Зураг 1. Орон сууцны хороололд нүүрэн талын барилга байгууламж төлөвлөх загвар (Жишээ зураг)


- 4.9. Дуу чимээний эх үүсвэрт ойр байгаа (Барилгын нүүрэн талын буюу зам руу харсан хэсэг нь 100м-ээс хүртэлт зайд) олон давхар орон сууцны барилгад барилга хот байгуулалтын норм дүрэмд заасан дуу чимээнээс тусгаарлах бүтээцийг төлөвлөж ашиглана (Зураг 2).



Зураг 2. Дуу чимээнээс хамгаалагдсан орон сууцыг гол замд ойр байхаар төлөвлөх (Жишээ зураг)


4.10. Барилгын эскиз болон ажлын зургийн үе шатанд дараах шаардлагуудыг хангана. Үүнд:

- 4.10.1. орон сууцны барилгын гадна, дотор хашлага бүтээцэд гудамж талаас болон барилгын доторх далд инженерийн тоног төхөөрөмжөөс ирэх дуу чимээ доргилтын хэмжээг бууруулах тусгаарлалт хийх;
- 4.10.2. орон сууцны барилгын унтлагын болон зочны өрөөг гудамжны дуу чимээ ихтэй орчноос аль болохоор холдуулж төлөвлөх;
- 4.10.3. орон сууцны барилгын цахилгаан шатыг унтлагын өрөөтэй зэрэгцээ байрлуулахыг хориглох бөгөөд бусад өрөө тасалгаатай зэрэгцээ төлөвлөх тохиолдолд дуу чимээг тусгаарлах;
- 4.10.4. орон сууцны барилгын сууц хоорондын хана, хаалтууд 50 дБА-аас доошгүй дуу чимээний тусгаарлалтын үзүүлэлттэй байхаар хийц, материал төлөвлөвөл зохистой;
- 4.10.5. дуу чимээний зөвшөөрөгдөх хэмжээг хангахын тулд ариун цэврийн дамжуулах хоолойнуудыг орон сууцны өрөө тасалгаанаас тусгаарласан хана, хаалтуудад бэхлэх, өрөөнүүдийн дээд талд болон зэрэгцүүлэн цахилгаан шат, машины өрөө байрлуулж төлөвлөхийг хориглоно.
- 4.10.6. орон сууцны барилгыг дуу чимээнээс хамгаалахдаа гал тогоо, ариун цэврийн өрөө, шат, цахилгаан шат, коридор болон 3-аас олон өрөөтэй айлын нэгээс илүүгүй өрөөг дуу чимээний эх үүсвэр рүү (гол зам) чиглэсэн байхаар тооцсон байна (Зураг 2.1).



Зураг 2.1 Дуу чимээнээс хамгаалагдсан орон сууцны дотоод зохион байгуулалт (Жишээ зураг)

4.11. Дуу чимээний хамгаалалттай орон сууцны барилгаас бусад зориулалттай барилгын нүүрэн тал нь 2 метрийн зайд замын талаас нөлөөлөх эх үүсвэр нь 75дБА ба түүнээс дээш бол тагт, лоожийг төлөвлөнө. (Зураг 3).



Зураг 3. Орон сууцны барилгад тагт төлөвлөх (Жишээ зураг)

- 4.12. Орон сууц болон дуу чимээ ихтэй байрыг заагладаг, дуу чимээг тусгаарлах шаардлагатай давхар хоорондын хучилтад хангалттай зузаан цул төмөр бетон хавтанг ашиглахаар зураг төсөлд тусгана.
- 4.13. Төмөр бетон, бетон, тоосго зэрэг хатуу материалаар хийсэн хана буюу хамар хананы агаарын дуу чимээ тусгаарлах чадварыг нэмэгдүүлэхийн тулд шахмал гелтгөнөт-картон хавтан, хатуу зоргодос хавтангаар бүрэх бөгөөд хана ба бүрхүүлийн хоорондын 40-50 мм зузаантай орон зайг дуу шингээх зөөлөн материалаар (эрдэст шилэн хөвөн мөн хавтан г.м.) дүүргэх шаардлагатай.
- 4.14. Орон сууц, олон нийтийн барилга болон үйлдвэрийн туслах барилгын зураг төсөл боловсруулахдаа доторх дуу тусгаарлах нормчлогдсон үзүүлэлтийн хангахуйц хийц, бүтээц сонгон төлөвлөнө.

5. ДУУ ЧИМЭЭНИЙ ХҮЛЦЭХ ХЭМЖЭЭ

- 5.1. Дуу чимээний хүлцэх хэмжээ нь газар ашиглалтын бүсээс хамаарч өдрийн цаг буюу 06.00-22.00 цаг хүртэлх хугацаанд шөнийн цаг буюу 22.00-06.00 цаг хүртэлх хугацаанд Зураг 4-д заасан шаардлагаас илүүгүй байна.



Зураг 4. Орчны дуу чимээний хүлцэх хэмжээ (Жишээ зураг)

- 5.2. Тээврийн хэрэгслийн дууны даралтын түвшнийг техникийн хяналтын үзлэгээр хянан шалгаж, хүлцэх хэмжээнээс хэтэрсэн дуу чимээ ялгаруулж байгаа эсэхийг тодорхойлох бөгөөд даралтын түвшин нь үндэсний болон энэхүү стандартын шаардлагыг хангасан байна.

- 5.3. Тээврийн хэрэгслээс үүсэх дуу чимээний зөвшөөрөгдөх түвшин буюу хүлцэх хэмжээг Хүснэгт 2, 3-т үзүүлэв.

Хүснэгт 2. Тээврийн хэрэгслийн гаднах дуу чимээний хүлцэх түвшин

Тээврийн хэрэгслийн төрөл		Автомашин дуу чимээний хүлцэх түвшин /Дба/
Суудлын автомашин		80
Автобус	3500 кг хүртэл	81
	3500 кг-аас дээш	82
	Хөдөлгүүр нь 162квт, түүнээс дээш чадалтай	85
Ачааны болон ачаа-суудлын автомашин	3500 кг хүртэл	81
	3500 кг-аас дээш	86
	12000 кг-аас дээш жинтэй, 162 квт-аас дээш чадалтай	88
Мотоцикл	175сс-ээс их /хөдөлгүүрийн хүч/	80

Хүснэгт 3. Тээврийн хэрэгслийн доторх дуу чимээний хүлцэх түвшин

Тээврийн хэрэгслийн төрөл		Автомашин дуу чимээний хүлцэх түвшин /дба/
Суудлын автомашин	Ачааны, суудлын, автобусны жолоочийн ажлын байранд	80
Автобус	Хот доторх хөдөлгөөн оролцох автобус	80
	Хот хоорондын хөдөлгөөн оролцох автобус	75

- 5.4. Орон сууцны тагт, террас орон сууцны гадна орон зай дахь дуу чимээний хүлцэх хэмжээ өдрийн цагт 55 дБА-аас хэтрэхгүй байх ёстой.
- 5.5. Орон сууцны фасадаас 1 метрийн зайд шөнийн цагт гадна орчны дууны түвшин 45 дБА-аас хэтрэхгүй байх ёстой.
- 5.6. Сургууль, цэцэрлэгийн бүсэд өдрийн цагт анги танхимд яриаг саадгүй ойлгохын тулд суурь дуу чимээний хүлцэх хэмжээ 35 дБА-аас хэтрэхгүй байх ёстой.
- 5.7. Эмнэлэгт шөнийн цагаар дуу чимээний хамгийн их утга нь дотоод орчинд 40 дБА-аас хэтрэхгүй байх ёстой.
- 5.8. Гадна зар сурталчилгааны лэд дэлгэц болон дуут усан оргилуураас үүсэх дуу чимээ нь орчны дуу чимээний хүлцэх хэмжээ (Зураг 8) -ээс +5 дБА-аас илүүгүй байна.
- 5.9. Хууль журамд өөрөөр заагаагүй бол задгай талбай, олон нийтийг хамарсан арга хэмжээнээс үүсэх дуу чимээ нь ойролцоох орон сууцны хороололд 65 дБА-аас хэтрэхгүй байна.

6. ДУУ ЧИМЭЭГ ХЭМЖИХ, ХЯНАХ ХЭРЭГСЭЛ

6.1. Дуу чимээг дараах багаж хэрэгслээр хэмжинэ. Үүнд:

- 6.1.1. дуу чимээ хэмжих нэгдүгээр ангиллын хэрэгсэл болон дууны чөлөөт орчны нөхцөлийг хэмжихэд зориулсан туслах үүсгэгч ашигласан чанга яригч хэрэгслүүд байна. Давтамжийн завсар нь 31.5 Гц-110кГц;
- 6.1.2. дуу чимээний нам давтамжийн генератор. Давтамжийн завсар нь 20 Гц-20кГц, хэмжилтийн хазайлт ± 3 дБА байна;
- 6.1.3. салхины хурд хэрэгсэл. Хэмжилтийн завсар нь 1-10м/с, хэмжилтийн алдаа 0.5 м/с байна;
- 6.1.4. хөдөлгүүрийн тахир гол эргэлтийн давтамж, автомашины хөдөлгөөний хурд хэмжихэд зориулсан хэрэгслүүд. Хэмжилтийн алдаа 3%-аас илүүгүй байна.



а. Дуу чимээ хэмжих нэгдүгээр ангиллын хэрэгсэл



б. Дуу чимээний нам давтамжийг хэмжих генератор



в. Салхины хурд хэмжих хэрэгсэл



г. Хөдөлгөөний хурд хэмжих хэрэгсэл

Зураг 5. Дуу чимээ хэмжигч багаж (Жишээ зураг)

6.2. Дуу чимээний бохирдлыг хянах:

- 6.2.1. Гадна орчны дуу чимээний бохирдлыг бууруулахын тулд Хотын стандарт, хяналтын газар хяналт тавьж ажиллана. Дуу чимээг хэмжих зориулалт бүхий мэдрэгчийг гудамж, замын сүлжээнд холбон суурилуулах боломжтой. (Зураг 6).



Зураг 6. Дуу чимээг тогтмол хянах төхөөрөмж (Жишээ зураг)




Зураг 7. Гэрэлтүүлгийн шонд суурилуулсан мэдрэгчийн байрлал (Жишээ зураг)

7. НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Дууны долгионыг сарниулах зорилгоор зохих хэмжээний ногоон байгууламжийг төлөвлөвөл зохино.

7.1. Ногоон байгууламж буюу модлог ургамал нь дуу чимээг сарниулах бөгөөд түүний үйлчлэл нь модны төрлөөс хамааран харилцан адилгүй байна (Зураг 8).




Зураг 8. Модны дуу чимээ бууруулах үйлчлэлийн хэмжээ (Жишээ зураг)

7.2. Үйлдвэрийн газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээг Үйлдвэрийн барилга, байгууламжийн төлөвлөлтийн эрүүл ахуйн норм БНБД 2.09.12-87 болон БНБД 30-01-21 норм, дүрмийг баримтлан тогтооно.

7.3. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зориулалтын газрын цэцэрлэгжүүлэлтийн доод хэмжээг экологийн болон архитектур төлөвлөлтийн нөхцөлийн нормативыг харгалзан тооцно. Үүнд:

300 м хүртэлх	60%;
300-аас 1000 м	50%;
» 1000 » 3000 м	40%;
» 3000 м	20%;

7.4. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн цэцэрлэгжүүлэлтийг суурьшлын бүсээс 50 м-ээс багагүй, 100 м бол 20 м хүртэл байхаар тооцож төлөвлөнө.



Зураг 9. Ногоон зурвасын төлөвлөлтийн жишээ (Жишээ зураг)

- 7.5. Хүн амын нягтаршил ихтэй хэсэгт оршин суугчдыг дуу чимээний бохирдлын сөрөг нөлөөллөөс хамгаалахын тулд цэцэрлэгт хүрээлэн, орон сууц, эмнэлэг, сургууль зэрэг олон нийтийн барилгын гадна талбайд ногоон байгууламж төлөвлөнө.¹
- 7.6. Томоохон цэцэрлэгт хүрээлэнд дуу чимээний зөвшөөрөгдөх хэмжээ 45 дБА-ээс хэтрэхгүй байна.²
- 7.7. Хотын төвийн орон сууц, олон нийтийн барилгын ногоон байгууламжийн бүс дэх дуу чимээний түвшин орчны дуу чимээний түвшингээс 6 дБА-ээр бага байна.³
- 7.8. Тээврийн хэрэгслийн дуу чимээнээс тусгаарлах зорилгоор авто замын дагуу 1 метрээс багагүй өргөнтэй ногоон зурвас төлөвлөнө. (Зураг 10).



Зураг 10. Зам дагуу ногоон байгууламж төлөвлөх (Жишээ зураг)


8. ТӨМӨР ЗАМЫН ТӨЛӨВЛӨЛТ

- 8.1. Төмөр замын станцыг хотын гадна байгуулах бөгөөд орон сууц, олон нийтийн байгууллага хоорондын зай ачаа эргэлтийн хэмжээ, тээвэрлэж буй барааны галын болон тэсэрч дэлбэрэх аюул, дуу чимээ, доргилт зэргээс шалтгаалан ойролцоогоор 150 м байна.
- 8.2. Орон сууцыг төмөр замын захын тэнхлэгээс 100 м-ийн өргөнтэй эрүүл ахуйн хамгаалалтын зурвасаар тусгаарлана. Төмөр замыг хонхор, хотгор газар, эсхүл норм, дүрмийн шаардлага хангасан дуу чимээ тусгаарлах тусгай байгууламж барих тохиолдолд ариун цэвэр хамгаалалтын бүсийн өргөнийг багасгаж болох ч 50 метрээс бага байж болохгүй (Зураг 11).

¹ 2,3 "Орон нутгийн дуу чимээний арга хэмжээний төлөвлөгөө" боловсруулах гарын авлага, Европын комисс

² 4 Дуу чимээний хаалтын дизайн, төлөвлөлтийн удирдамж, Хонг Конг

³ 5 Байгаль орчин хамгааллын газар, 2003



Зураг 11. Төмөр замын төлөвлөлт (Жишээ зураг)

- 8.3. Төмөр замын ачаа, тээш ангилж, ялган хуваарилах станцыг хот, суурины бүсийн гадна байрлуулна.
- 8.4. Төмөр замын дуу чимээний бохирдолд өртөх магадлалтай суурьшлын бүсэд шинээр орон сууцны барилга барихад дуу чимээний нөлөөллийн үнэлгээ хийлгэнэ.⁴
- 8.5. Төмөр замаас үүдэлтэй дуу чимээг бууруулахын тулд галт тэрэгний хурдны хязгаарлалт хийх, явах чиглэл, цагийн хуваарийг өөрчилнө.⁵

9. БАРИЛГА, ОРОН СУУЦЫН ДУУ ЧИМЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шинээр ашиглалтад орж буй барилга, орон сууцын дуу чимээний үзүүлэлтийг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу хянан үзнэ.

⁴ “Дуу чимээний хяналт зохицуулалтын журам”, Английн Байгаль Орчин, Хүнс, Хөдөө Орон Нутгийн Харилцааг Зохицуулах Газар, 2006

⁵ “Дуу чимээний хяналт зохицуулалтын журам”, Английн Байгаль Орчин, Хүнс, Хөдөө Орон Нутгийн Харилцааг Зохицуулах Газар, 2006

Хүснэгт 4. Шалгах хуудас

Шалгах үзүүлэлт		Тийм	Үгүй
Нийтлэг шаардлага	Барилгын зураг төсөл нь тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Барилгын зураг төсөл нь эскиз зургийн түвшинд Архитектур төлөвлөлтийн даалгаврын тусгай шаардлагын дагуу дуу чимээний тооцоолол хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Барилгын архитектурын төлөвлөлтөд дуу чимээ бууруулах хүчин зүйлсийг харгалзан үзэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Тухайн барилга нь Төмөр зам, авто зам зэрэг дуу чимээний эх үүсвэртэй ойр оршдог бол стандартын дуу чимээний хаалт, хашлага хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Сууцны барилгын гадна, дотор хашлага бүтээцэд гудамж талаас болон барилгын доторх далд инженерийн тоног төхөөрөмжөөс ирэх дуу чимээ доргилтын хэмжээг бууруулах тусгаарлалт хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Орон сууцны барилгын унтлагын болон зочны өрөөг гудамжны дуу чимээ ихтэй орчинд төлөвлөөгүй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Орон сууцны барилгын цахилгаан шатыг унтлагын өрөөтэй зэрэгцээ байрлуулж төлөвлөөгүй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Барилгын унтлагын болон зочны өрөөний дуу чимээний хүлцэх хэмжээ өдрийн цагт 50дБА-тай, шөнийн цагт 40дБА-тай тэнцүү эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Орон сууцны утлагын өрөөний чанх доод талд хүүхдийн тоглоомын талбай төлөвлөөгүй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Орон сууцны, барилга байгууламжийн гадаад орчин өдрийн цагт 50 дБА, шөнийн цагт 40дБА байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Бүтээцийн шаардлага	Орон сууц болон дуу чимээ ихтэй байрыг заагладаг, агаарын дуу чимээг тусгаарлах шаардлагатай давхар хоорондын хучилтад хангалттай зузаан цул төмөр бетон хавтанг ашигласан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Дуу чимээний эх үүсвэрийн талын цонх илүү зузаан эсхүл давхар шил ашигласан эсэх, Шилний давхаргыг 2-3 дахин нэмэглүүлсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Барилга, орон сууцны хаалга 100-150 мм-ын орон зайгаар тусгаарлагдсан давхар хаалга байгаа эсэх эсхүл хаалгыг дуу чимээг бууруулах төмөр ган, хатуу модоор хийсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Барилгын гадна хананд дуу, дулаан тусгаарлагч материал оруулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Барилгын дотоод засалд дуу тусгаарлагч акустик хавтан, акустик өнгөлгөө зэрэг материал ашигласан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Дээвэр таазны хоорондох хөндийд 200-300мм дулаан акустик тусгаарлагч суурилуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Таазыг дуу чимээ шингээгч материалаар хийсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Шалны өнгөлгөөн доор дуу тусгаарлагч материал хийсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа бол **тийм** баганад, хангахгүй байгаа бол **үгүй** баганад тэмдэглэгээ хийнэ.

Анхаар: Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг зааврын дагуу ашиглаж, зөв хэмжилт хийх шаардлагатай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- “Орчны чанарын стандарт” Япон улсын Осака хотын Байгаль орчны агентлагийн 1998 оны 9-р сарын 30-ны өдрийн 65-р тогтоол;
- “Дуу чимээний бохирдлыг бууруулах тухай” дүрэм, Швейцарийн Үндэсний Зөвлөлийн 1986 оны 12-р сарын 15-ны өдөр;
- “Орчны дуу чимээний менежмент, үнэлгээ”, Европын парламентийн 2002 оны 6-р сарын 25-ны өдрийн 2002/49/ЕС зөвлөмж;
- Берт,К., Коллинс,К. (1974). “Хурдны замын дуу чимээ ба газар ашиглалт” гарын авлага. АНУ: АНУ-ийн Авто Замын Газар;
- Роберт.А.Хенден. (1980). Дуу чимээ тусгаарлах материалын эмхэтгэл. АНУ: Америкийн Үндэсний Эрүүл мэнд, Аюулгүй байдлын Институци;
- Биргитта Берглунд, Т. Л. (1999). Орны дуу чимээний удирдамж. Женев хот: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага;
- Алберти, П.В нар. (1999). Дуу чимээнд өртөлтийн үнэлгээ, урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээ. Женев хот: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага;
- Байгаль орчны газар. (1999). Дуу чимээний бохирдлыг бууруулах удирдамж, Малайз улс;
- Беренис Гоелцер, К. Х. (2001). Дуу чимээнд өртөлтийн үнэлгээ, урьдчилан сэргийлэлт, хяналт . Дортмунд, Герман: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага;
- Франк Аббул, М. Б. (2002). Дуу чимээний бохирдлыг бууруулах талаар ойлголт. Бэрн, Швейцарь: Швейцарийн Байгаль орчин, Ой, Ландшафтын Агентлаг;
- Байгаль орчин хамгааллын газар. (2003). Дуу чимээний хаалтын дизайн, төлөвлөлтийн удирдамж, Хонг Конг;
- Вэйкфийлд Акустик ХК. (2004). Дуу чимээний хяналт, зохицуулалтын удирдамж. Канад: Ванкувер хотын захиргаа;
- Мелани Клот, К. В. (2007). "Орон нутгийн дуу чимээний арга хэмжээний төлөвлөгөө" боловсруулах гарын авлага. Австри: Европын комисс;
- Элиот Палмер. (2007). Байгаль орчны хамгаалал: Суурьшлийн бүсийн дуу чимээний хяналт, зохицуулалт. Австрали: Викторий мужийн Байгаль Орчин Хамгааллын Газар;
- Ник Кравен. (2013). Төмөр замын дуу чимээг бууруулах техникийн арга хэмжээний каталоги. Олон Улсын Төмөр Замын Холбоо;
- Байгаль Орчин Хамгааллын Газар. (2013). Орон нутгийн захиргаанд зориулсан дуу чимээний удирдамж. Австрали: Нью Саут Вэлс мужийн захиргаа;
- Дэ Пайва Вианна, К.М., Алвес Кардосо. (2015). Дуу чимээний бохирдол ба уур бухимдал: Дуу чимээ ба эрүүл мэнд. Сау Пауло, Бразил улс;
- Хайбо Ванг, Пэнг Луо, Минг Чая. (2018). Тээврийн хэрэгслээс үүдэлтэй дуу чимээний давтамжаас хамааруулан хаалтын дуу чимээ бууруулах хэмжээг тооцоолох. БНХАУ: Олон Салбарын Дижитал Хэвлэлийн Хүрээлэн MDPI.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, хяналтын газар